

БЭЛЭН МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ

ТҮҮВЭР СУДАЛГАА¹

Ц.Цэрэндаваа², Д.Золбоо³

Хураангуй: Энэхүү судалгаанд бэлэн мөнгөний хэрэглээг тухайн өдөр бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр тооцооны тоо, үнийн дүн болон иргэдийн өдрийн эхэн, эцэст биедээ авч явж буй бэлэн мөнгөний хэмжээгээр тодорхойлж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн бэлэн мөнгө ашиглах болон хадгалах зан төлөвийг хамтатган шинжиллээ. Судалгааг 2025 оны 10–11 дүгээр сард зохион байгуулж, байршил, нас, хүйс, орлогын бүлгээр эх олонлогийг төлөөлсөн 2,131 иргэн болон 540 бизнес эрхлэгч аж ахуйн нэгж хамрагдсан бөгөөд бизнес эрхлэгчид нь голлон жижиг, дунд хэмжээний худалдаа эрхлэгчид байв. Судалгааны үр дүнгээс харахад бэлэн мөнгө нь бага дүнтэй, өдөр тутмын төлбөр тооцоонд чухал үүрэгтэй хэвээр байна. Иргэдийн 28 хувь нь огт бэлэн мөнгө авч явдаггүй боловч медиан утгаар иргэд өдрийн эхэнд 10,000 төгрөг авч явж, АТМ, КИОСК-оос 20,000 төгрөгийн бэлэн мөнгө нэмж татан авч, өдөртөө 16,000 төгрөгийг бэлнээр зарцуулан, өдрийн эцэст дунджаар 14,000 төгрөг үлддэг байна. Нийт төлбөр тооцооны тооны дунджаар 27 хувийг, дүнгийн 18 хувийг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд тэтгэврийн насныхан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд бэлэн мөнгөний хэрэглээ харьцангуй өндөр байна. Гэсэн хэдий ч бэлэн мөнгө огт ашигладаггүй болон маш ховор ашигладаг иргэдийн эзлэх хувь өндөр байгаа нь бэлэн мөнгө нь үндсэндээ жижиг дүнтэй гүйлгээнд төвлөрч буйг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 84 хувь нь бэлэн төлбөрийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь тэдний сонголтоос илүүтэй хэрэглэгчдийн төлбөрийн зан төлөвтэй холбоотой байна. Кассандаа бэлэн мөнгө байршуулдаг бизнесүүдийн медиан үлдэгдэл ойролцоогоор 500,000 төгрөг бөгөөд борлуулалтын орлогынхоо 25 хувиас бага хэсгийг бэлэн мөнгөөр хүлээн авдаг ажээ.

Мөнгөн дэвсгэртийн хэрэглээний хувьд иргэд болон бизнес эрхлэгчдийн дунд 20,000, 10,000, 5,000 төгрөгийн дэвсгэртүүд хамгийн өргөнөөр ашиглагддаг бол 1 болон 5 төгрөгийн дэвсгэртүүд бараг ашиглагдахгүй болжээ. Эдгээр үр дүн нь Монгол Улсад бэлэн болон бэлэн бус төлбөрийн хэрэгслүүд зэрэгцэн оршиж буй өнөөгийн нөхцөлд мөнгөн тэмдэгтийн бүтэц, дэвсгэртийн бодлого болон бэлэн мөнгөний дэд бүтцийг оновчтой төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

JEL код: D14, L81, E41, E42, E58

Түлхүүр үгс: өрхийн санхүүгийн зан төлөв, бөөний болон жижиглэн худалдаа, мөнгөний эрэлт, төлбөрийн систем, төвбанкны бодлого

¹ Иргэд, аж ахуйн нэгжүүдээс түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах ажилд туслалцаа үзүүлсэн Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газрын болон орон нутгийн салбар, хэлтсүүдийн нийт ажилтнуудад гүн талархал илэрхийлье.

² Монголбанк, Судалгаа, Статистикийн газар, Судалгааны хэлтэс, Ахлах эдийн засагч Цахим хаяг: tserendavaa.ts@mongolbank.mn

³ Монголбанк, Судалгаа, Статистикийн газар, Судалгааны хэлтэс, Эдийн засагч Цахим хаяг: zolboo.d@mongolbank.mn

АГУУЛГА

1. УДИРТГАЛ.....	3
2. ИРГЭДИЙН БЭЛЭН МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ	4
2.1. Түүвэрлэлт	4
2.2. Түүвэр судалгааны ерөнхий мэдээлэл	4
2.3. Бэлэн мөнгө хэрэглэх зан төлөв.....	7
2.4. Төлбөр тооцоо	16
2.5. Төлбөрийн хэрэгслийн ашиглалт	22
2.6. Бэлэн мөнгөний хэрэглээ.....	25
3. АЖ АХУЙН НЭГЖИЙН БЭЛЭН МӨНГӨНИЙН ХЭРЭГЛЭЭ	26
3.1. Түүвэрлэлт	26
3.2. Түүвэр судалгааны ерөнхий мэдээлэл	28
3.3. Төлбөрийн хэрэгслүүдийг хүлээн зөвшөөрдөг байдал.....	31
3.4. Бэлэн мөнгө хэрэглэх зан төлөв.....	33
4. МӨНГӨН ДЭВСГЭРТҮҮДИЙН ХЭРЭГЛЭЭ	45
5. ДҮГНЭЛТ	48

1. УДИРТГАЛ

Мөнгөн тэмдэгт нь эдийн засагт солилцооны хэрэгсэл, үнийн хэмжүүр, хадгаламжийн хэрэгсэл болон хууль ёсны төлбөрийн хэрэгсэл гэсэн суурь үүргийг гүйцэтгэдэг. Дижитал төлбөрийн хэрэглээ эрчимтэй нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд ч бэлэн мөнгө нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хүртээмжийг дэмжих, төлбөрийн системийн доголдлын үед нөөц хувилбар болох, мөнгөний бодлогын шилжих механизмыг (*monetary policy transmission mechanism*) ойлгох зэрэг үүднээс ач холбогдлоо хадгалсаар байна. Нөгөөтэйгүүр, иргэд үр ашигтай, аюулгүй, хүртээмжтэй байдлаар төлбөр тооцоо хийх боломжтой байх нь үндэсний мөнгөн тэмдэгт “ТӨГРӨГ”-т итгэх итгэлийг хадгалахад чухал ач холбогдолтой юм.

Монголбанк нь Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах замаар гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах онцгой эрх бүхий байгууллагын хувьд мөнгөн тэмдэгтийн хэрэглээ, түүний онцлог, хэрэглэгчдийн зан төлөвийг судлах нь зайлшгүй шаардлагатай. Гэсэн хэдий ч иргэдийн бэлэн мөнгөөр хийгдэх төлбөр тооцооны бодит хэрэглээ, зан төлөвийн талаарх анхдагч мэдээлэл харьцангуй хомс байна.

Иймд, тус судалгаагаар иргэд болон аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн хэрэгслийн хандлага, хүлээн зөвшөөрдөг байдал, мөнгөн дэвсгэртүүдийн хэрэглээний ялгаатай байдал, бэлэн мөнгөөр хийгдэх төлбөр тооцооны эргэлтийг тооцоолох зорилгоор гүйцэтгэсэн бөгөөд судалгаа нь улсын хэмжээнд иргэд болон аж ахуйн нэгжүүдийг хамруулсан гэдгээрээ онцлог болж байна.

Энэхүү судалгаанд бэлэн мөнгөний хэрэглээг тодорхойлохдоо урсгал (*flow*) болон нөөц (*stock*) үзүүлэлтийг тусад нь авч үзсэн бөгөөд бэлэн мөнгөний хэрэглээг тухайн өдөр бэлэн мөнгөөр хийгдсэн гүйлгээний нийлбэрээр тодорхойлж, харин өдрийн эхэн болон эцэст авч явж буй бэлэн мөнгөний хэмжээг иргэдийн бэлэн мөнгө хадгалах зан төлөвийг илэрхийлэх үзүүлэлт болгон ашиглалаа.

Түүвэр судалгааг 2025 оны 10-11 дүгээр саруудад зохион байгуулж, нэгтгэсэн үр дүнг энэхүү тайлангаар танилцуулж байна. Тайлан нь (1) иргэд, (2) аж ахуйн нэгжүүд гэсэн хоёр үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд бүлэг тус бүрийн хувьд бэлэн мөнгөний хэрэглээний зан төлөв, төлбөр тооцооны онцлогийг харуулсан үр дүнг багтаалаа.

2. ИРГЭДИЙН БЭЛЭН МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ

2.1. Түүвэрлэлт

Уг түүвэр судалгааны хамрах хүрээний хувьд Монгол Улс (МУ)-д оршин суугаа насанд хүрсэн иргэдийг хамруулсан бөгөөд Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээлснээр 2024 оны байдлаар МУ-д оршин суугаа насанд хүрсэн⁴ **2,082,524** иргэн байна. Уг хүн амыг эх олонлог болгон авч, 95 хувийн итгэх завсарт, 2.2 хувийн ахиуц алдааны утгаар хамгийн бага оновчтой түүврийн хэмжээг тооцоход 1,982 болж байна (Хүснэгт 1). Судалгааны түүвэрлэлт хийхдээ Улаанбаатар хот болон 21 аймагт оршин суугаа иргэдийн тоог нийт иргэдийн тоонд харьцуулж, хувийн жин, газар зүйн байршлыг харгалзан дүүрэг болон аймаг тус бүрээс авах оновчтой түүврийн хамгийн бага хэмжээг тооцсон. Энэхүү судалгаанд нийт **2,131** иргэн буюу нийт эх олонлогийн 0.1% нь хамрагдсан бөгөөд нийт эх олонлогийг бүрэн төлөөлөхүйц түүвэр боллоо.

Хүснэгт 1. Түүвэрлэлтийн аргазүй

$$p = \frac{Z^2 * r(1 - r) * NN}{(NN - 1) * E^2 + Z^2 * r(1 - r)}$$

Оновчтой түүврийн хэмжээ: $p=1,535$

Тэмдэглэгээ	Утга	Тайлбар
NN	2,082,524	Эх олонлог буюу нийт иргэдийн тоо
Z	1.96	95%-ийн итгэх интервал
R	0.5	Тогтмол утга
E	2.2%	Алдааны хязгаар

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2.2. Түүвэр судалгааны ерөнхий мэдээлэл

Тус түүвэр судалгааны хувьд төлбөр тооцооны ялгаатай үеүдийг бүрэн хамруулахын тулд 2025 оны 10-11 дүгээр саруудад долоо хоногийн бүх өдрүүдэд биечлэн ярилцлага хийх болон Random Digit Dialing⁵ (RDD) байдлаар мэдээлэл цуглуулж ажиллалаа. Гэсэн хэдий ч иргэдийн оролцооны идэвх сул байснаас үүдэж амралтын өдрүүдэд харьцангуй


⁴ Насны бүлгийн ангилал нь “15-19” болон “20-24” гэсэн ангилалтай байх бөгөөд 20-с дээш насны бүлгийн ангиллуудыг авч тооцсон болно.

⁵ Санамсаргүй байдлаар 8 орон бүхий дурын дугаарлалт үүсгэж, тухайн дугаарт судалгаанд оролцох урилга мессежийг өдөр бүр ижил тоогоор илгээсэн. Ингэхдээ үүрэн холбооны хэрэглэгчдийн операторуудын эзлэх хувиар нийт дугаарлалтыг үүсгэв.


бага иргэд судалгаанд хамрагджээ. Харин ажлын өдрүүдэд иргэд судалгаанд жигд хамрагдсан нь төлбөр тооцооны хувьд өдрийн ялгаатай байдлыг бууруулсан. Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн 45% буюу 965 нь Улаанбаатар хотод, 55% буюу 1,166 нь орон нутагт харьяалагдаж байна. Мөн аймаг болон дүүргийн түвшинд эх олонлогийн бүтэцтэй ижил байдлаар түүвэрлэлтийг бүрдүүллээ.

Зураг 1. Судалгаанд оролцогч иргэдийн мэдээлэл


а) Мэдээлэл цуглуулсан гараг



б) Байршил



в) Оршин суугаа аймаг



г) Оршин суугаа дүүрэг




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Түүнчлэн судалгаанд оролцсон иргэдийн 16% нь 18-25 насны, 21% нь 26-35 насны, 30% нь 36-45 насны, 19% нь 46-55 насны, үлдсэн 14% нь 56-аас дээш насны хүмүүс байна. Тэдгээрийн 39% эрэгтэй, 61% нь эмэгтэй байна. Мөн боловсролын байдлыг авч үзвэл судалгаанд оролцсон иргэдийн 60% нь дээд, 29% нь бүрэн дунд, 6% нь техник болон

мэргэжлийн, 4% нь бүрэн бус дунд шатны боловсролтой иргэд байна. Харин ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл, 38% нь хувийн байгууллагад, 24% нь төрийн байгууллагад, 13% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол тэтгэвэрт гарсан иргэд 10%-ийг, ажилгүй болон бусад хэлбэрийн ажил эрхлэлттэй иргэд 4%-ийг тус тус бүрдүүлж байна (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд оролцогч иргэдийн мэдээлэл




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Судалгаанд оролцогчдын 67 хувь нь 3-5 өрхийн гишүүдтэй оролцогчид байсан бөгөөд орлогын түвшнээр нь авч үзвэл 1.6 саяас 2.1 сая төгрөг, 2.1 саяас 3.0 сая төгрөгийн орлоготой иргэн тус тус 21% байгаа бол 1.1 саяас 1.6 сая төгрөгийн орлоготой иргэн 18%-ийг бүрдүүлжээ. Харин судалгаанд хамрагдсан иргэдийн 10%-ийг бага орлоготой буюу 700 мянган төгрөгийн орлоготой иргэн, 9%-ийг 4 сая төгрөгөөс дээш орлоготой иргэд бүрдүүлж байна (Зураг 3).

Зураг 3. Судалгаанд оролцогчдын өрхийн мэдээлэл

а) Ам бүл



б) Орлого



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий мэдээллийг харахад байршил, насны ангилал, хүйс болон орлогын бүлгээр эх олонлогийн бүтэцтэй ойролцоо буюу тус үзүүлэлтүүдээр үзүүлэлт бүрийг дэлгэрүүлэн харьцуулах боломжтой болж байна. Мөн бэлэн мөнгөний болон төлбөр тооцооны зан төлөвийн байдал нь тухайн хүний боловсрол болон ажил эрхлэлтийн онцлогоос шалтгаалах боломжтой тул эдгээр ялгааг тодруулахын тулд боловсрол болон ажил эрхлэлтийн үзүүлэлтээр цаашид тус бүрд нь харьцуулан судална.

2.3. Бэлэн мөнгө хэрэглэх зан төлөв

Өдрийн эхэнд авч явж буй бэлэн мөнгөний хэмжээ нь иргэдийн урьдчилан төлөвлөсөн бэлэн мөнгөний эрэлт болон өдөр тутмын төлбөр тооцоонд бэлэн мөнгө ашиглах хандлагыг илэрхийлдэг. Зураг 4-т иргэдийн өдрийн эхэнд биедээ авч явж буй бэлэн мөнгөний хэмжээний тархалтыг харуулав. Тархалт нь мэдэгдэхүйц баруун тийш хазайсан бөгөөд медиан утга 10.0 мянган төгрөг, дундаж утга 31.9 мянган төгрөг байна. Энэ нь иргэдийн ихэнх нь харьцангуй бага хэмжээний бэлэн мөнгө авч явдаг боловч цөөн тооны иргэн их хэмжээний бэлэн мөнгө авч явж байгаагаас шалтгаалан нийт дундаж өссөн болохыг илтгэж байна. Иймд медиан үзүүлэлт нь иргэдийн “ердийн” бэлэн мөнгө авч явах зан төлөвийг илүү бодитой илэрхийлж байна. Түүнчлэн, судалгаанд оролцогч иргэдийн ойролцоогоор 28 хувь нь өдрийн эхэнд огт бэлэн мөнгө авч явдаггүй байдал нь дижитал буюу бэлэн бус төлбөрийн хэрэглээ тодорхой бүлгүүдэд өргөн тархсаныг илтгэж байна.

Зураг 4. Өдрийн эхэнд биедээ авч явж буй бэлэн мөнгөний хэмжээний тархалт, төгрөгөөр



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Байршлаас үл хамааран медиан утга ижил байгаа нь иргэдийн “ердийн” бэлэн мөнгө авч явдаг хэмжээ төстэй байгааг илтгэж байна. Харин орон нутагт дундаж утга харьцангуй өндөр байгаа нь бэлэн мөнгөний хамаарал илүү болохыг харуулж байна.

Нас ахих тусам өдрийн эхэнд авч явж буй бэлэн мөнгөний медиан хэмжээ тогтвортой өсөж байгаа нь ахмад настнууд дижитал бус төлбөрийн хэрэгслийг түлхүү ашиглаж, бэлэн мөнгөнд илүү найдаж байгааг илтгэнэ. Хүйсийн хувьд “ердийн” бэлэн мөнгө авч явдаг хэмжээ ижил байгаа боловч эрэгтэйчүүдийн дундаж утга өндөр байгаа нь их хэмжээний бэлэн мөнгө барьдаг цөөн хэсэг эрэгтэйчүүдэд илүү төвлөрч байгааг харуулж байна. Боловсролын түвшнээр авч үзвэл техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэдийн бэлэн мөнгө авч явдаг хэмжээ харьцангуй өндөр байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн онцлог, салбарын төлбөр тооцооны хэлбэртэй холбоотой байж болох юм (Зураг 6.а). Тэтгэвэрт болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бэлэн мөнгө авч явдаг хэмжээ бусад бүлгүүдээс мэдэгдэхүйц өндөр байгаа нь орлогын хэлбэр, төлбөр тооцооны давтамж, дижитал үйлчилгээний хэрэглээтэй холбоотой байж болох юм. Орлогын түвшин өсөхийн хэрээр дундаж утга өсөх хандлага ажиглагдаж байгаа боловч медиан харьцангуй тогтвортой байна (Зураг 6.б).

Шигтгээ 1. Орчин цагийн мөнгөн тэмдэгтийн түүх

Монгол Улсын тусгаар тогтнол эргэн сэргэн мандахтай зэрэгцэн 1921 оны 3 дугаар сард үндэсний санхүүгийн системийн эх суурийг тавьж, 1924 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Монголын Худалдаа, Аж Үйлдвэрийн Банк” (МХАҮБ) байгуулагджээ. Эдийн засаг дах банкны байр суурийг мэдэгдэхүйц нөлөөтэй болгох ажлуудыг үүнээс хойш хэрэгжүүлснээр үндэсний мөнгөн тэмдэгтийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж чаджээ. Улмаар 1925 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монгол ардын засгийн газраас мөнгөний шинэчлэл хийх түүхэн тогтоол гарч, 1925 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Монголын үндэсний шинэ мөнгөн тэмдэгтээр 900 сорьцын 18 граммын жин бүхий цагаан мөнгөн зоосыг батлан гаргаж "ТӨГРӨГ" гэж нэрлэн цагаан мөнгөн зоосны зэрэгцээгээр цаасан тэмдэгтийг гүйлгээнд гаргажээ.

Монгол Улсын төсвийн тооцоог 1925 он хүртэл лангаар, 1925 оноос хятадын янчаанаар гүйцэтгэж байсан бол 1926 оны эцсээр “Мөнгөний явдлыг шинэчлэн сайжруулах комисс”-оос улсын санхүүгийн тооцоог төгрөгөөр тооцох тухай тогтоол гаргаж байв. Мөн Мөнгөний шинэчлэлт хийх нь ард түмний ашиг сонирхолд нийцсэн хувьсгалт арга хэмжээ байсан учраас Монголын нийт ард түмний ухамсартай дэмжлэгийг хүлээсэн байна. Ийнхүү шинэ мөнгөн тэмдэгт "ТӨГРӨГ" зах зээл дээр ноёлох чадвартай үндсэн валют болон хувирчээ.

1925 онд бичиг, тоог монгол үсгээр бичиж, өлзий хээ, үелсэн хээтэй, өөр хамгаалалтын үзүүлэлтгүй цаасан дээр 1, 2, 5, 10, 25, 50, 100 төгрөгийн дэвсгэртүүд хэвлэсэн байдаг. 1939 онд мөнгөн дэвсгэртийн нүүрэн талд Соёмбо болон Д.Сүхбаатарын хөргийг адил хэмжээтэйгээр байрлуулж, ар талыг үндэсний хээ, угалзаар чимэглэж, бүх үгийг уйгаржин монгол бичгээр бичин, ЗХУ-д үйлдвэрлэжээ. Тус онд хэвлэгдсэн дэвсгэртүүд нь өмнөх дэвсгэртүүдийн хэмжээг өөрчлөхгүйгээр, 2-тын дэвсгэртийг 3-тын дэвсгэртээр сольж гаргасан онцлогтой. 1941 оны 1, 3, 5, 10, 25, 50, 100 төгрөгийн дэвсгэрт бүхий мөнгөн тэмдэгт нь 1939 оны мөнгөн тэмдэгтийн хэмжээ, өнгө, хээг өөрчлөхгүйгээр, Д.Сүхбаатарын хөргийг хэвээр байрлуулж, Соёмбын оронд 1940 онд батлагдсан үндсэн хуулиар шинэчлэгдсэн таван хошуу мал бүхий сүлдийг байрлуулж, үг, тоог уйгаржин монгол бичиг, кирилл бичгээр хослуулан бичиж, ЗХУ-д үйлдвэрлэжээ.

Монгол Улсын санхүү зээлийн систем бэхэжсэнийг харгалзан, түүний улс ардын аж ахуйн цаашдын хөгжилд түлхэц өгөх үүднээс ЗХУ-ын Засгийн газар 1954 онд Монголбанкин дахь өмчийн өөрийн хувь хэсгийг буцалтгүйгээр БНМАУ-д шилжүүлж, 1954 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн тогтоолоор МХАҮБ-ийг БНМАУ-ын “Улсын банк” болгон

өөрчлөн зохион байгуулжээ. Улсын банк нь 1955 онд Монгол Улсын шинэчилсэн цаасан мөнгөн тэмдэгтүүдийг БНМАУ-ын их хурлын 1949 оны тогтоолоор 1940 онд батлагдсан сүлд дээрх улсын нэрийн бичээсийг кирилл үсгээр сольсон сүлд болон Д.Сүхбаатарын хөрөг бүхий зураач Шибу, Төрийн шагналт, ардын зураач Д.Амгалан нарын зохиосон загвараар 1, 3, 5, 10, 25, 50, 100 төгрөгийн дэвсгэрттэйгээр Зөвлөлт Холбоот Улсын Москва хот дахь Гознакийн хэвлэх үйлдвэрт хэвлүүлсэн байна.

1966 оны мөнгөн тэмдэгтүүдийн загварыг 1960 онд батлагдсан үндсэн хуулиар шинэчлэгдсэн БНМАУ-ын сүлд болон Д.Сүхбаатарын хөрөгтэйгөөр зураач Ц.Минжүүр, Д.Цэрэнпил нар зурсан бөгөөд дэвсгэртүүдийн хэмжээг гүйлгээнд хэрэглэхэд тохиромжтой болгон 1955 оны загвараас жижгэрүүлэн, серийн дугаарыг нүүрэн талаас ар талд шилжүүлэн байрлуулж, өнгө, зураг, загварыг шинээр өөрчлөн бүтээсэн байдаг. Эдгээр мөнгөн дэвсгэртүүд нь нүүрэн талын суурь нь үелсэн зураасан хээтэй, ар талын суурь нь сүлжилдсэн зураасан хээтэй, нүүрэн талын зүүн болон ар талын баруун хэсэгт 20 мм өргөн цулгүй цагаан зайтай, нүүрэн талын тус зайн дээрх зураасан цэцгэн хээний голд уйгаржин тоогоор тухайн дэвсгэртийн нэрлэсэн үнийг дүрслэн, мөн өлзий хээ болон бусад үелсэн хээтэй, өөр хамгаалалтын үзүүлэлтгүй цаасан дээр хэвлэжээ. 1966 оны шинэ тэмдэгтийг гүйлгээнд оруулахдаа урьд нь гүйлгээнд хэрэглэгдэж байсан бүх цаасан мөнгөн тэмдэгтүүдийг богино хугацаанд солих байдлаар гүйлгээнээс татсан байна.

1966 онд хэвлэгдсэн 25 төгрөгийн дэвсгэртийн дүнг тоолох, шалгахтай холбогдсон техник ажиллагаа нь бусад тэмдэгтүүдтэй харьцуулахад төвөгтэй байгааг харгалзан дахин хэвлүүлэхгүйгээр, харин түүний оронд бусад орнуудын туршлага дээр үндэслэн 1981 онд Монгол Ардын Хувьсгалын 60 жилийн ойд зориулан 20 төгрөгийн дэвсгэртийг шинээр гүйлгээнд гаргахаар шийдвэрлэж, зураач Р.Алтанхуягийн зурсан загвараар тус мөнгөн дэвсгэртийг ЗХУ-д үйлдвэрлүүлсэн. Ийнхүү БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1981 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 167 дугаар тогтоолын дагуу БНМАУ-ын Улсын банкны ерөнхий хороо 20 төгрөгийн дэвсгэртийг 1981 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс гүйлгээнд гаргав.

1925, 1939, 1941, 1955 онуудын мөнгөн тэмдэгтэд хуурамчаар үйлдэхээс хамгаалсан тусгай хийц байгаагүй, зөвхөн цаас, зураг хээ нь мөнгөн тэмдэгтэд зориулагдсан онцлог хийцээр бүтсэн бөгөөд цаасны найрлагын 3/5-ийг хөвөн, 2/5-ийг нийлэг эд, маалинга, бусад хольц эзэлдэг байв.

Зах зээлийн нийгэмд шилжсэн үеэс эхлүүлэн мөнгөн дэвсгэртийн үнэ цэнийн хэмжээ, масштабт томоохон өөрчлөлт оруулах макро эдийн засгийн зайлшгүй шаардлага үүссэн бөгөөд 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ Үндсэн хуулиар улсын нэр, төрийн сүлд, далбааг өөрчилсөн тул мөнгөн дэвсгэрт дээр эдгээр өөрчлөлтүүдийг оруулах улс төр, нийгмийн зайлшгүй шаардлага зүй ёсоор урган гарсан.

Тиймээс Монголбанк томоохон өөрчлөлт хийж, “500” төгрөгийн дэвсгэртийг 1993 оны 5 дугаар сарын 20-ны өдөр, “50”, “100” төгрөгийн дэвсгэртүүдийг 1993 оны 7 дугаар сард, “5”, “1000” төгрөгийн дэвсгэртүүдийг 1993 оны 10 дугаар сард тус тус гүйлгээнд гаргасан байна. Түүнчлэн “1”, “10”, “20” төгрөгийн дэвсгэртийг 1994 оны 1 дүгээр сард, “5000” төгрөгийн дэвсгэрт болон “10”, “20”, “50”, “200” төгрөгийн зоосон мөнгөн тэмдэгтийг 1995 оны 5 дугаар сард, “10000” төгрөгийн дэвсгэртийг 1996 оны 1 дүгээр сард тус тус гүйлгээнд гаргажээ.

Өмнө хэвлэсэн дэвсгэртүүдийн эрэлт ихэссэн байдлыг харгалзан 2006 онд “20000” төгрөгийн дэвсгэртийг гүйлгээнд гаргаснаар Манай Улсад одоогийн байдлаар 11 төрлийн цаасан (1₮, 5₮, 10₮, 20₮, 50₮, 100₮, 500₮, 1000₮, 5000₮, 10000₮, 20000₮), 5 төрлийн зоосон (20₮, 50₮, 100₮, 200₮, 500₮) мөнгөн тэмдэгт гүйлгээнд хүчин төгөлдөр ашиглагдаж байна.

Зураг 5. Үндэсний мөнгөн тэмдэгт “ТӨГРӨГ”-ийн түүхэн хөгжил



Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн өдрийн эхэнд авч явж буй бэлэн мөнгөний хэмжээ нь нас, ажил эрхлэлт, орлогын түвшнээс хамааран ялгаатай байгаа бөгөөд бүх бүлэгт дундаж утга медианаас өндөр байгаа нь бэлэн мөнгө авч явах зан төлөв жигд бус байгааг харуулж байна. Ялангуяа тэтгэврийн ахмад настан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд бэлэн мөнгөний хэрэглээ харьцангуй өндөр байна (Зураг 6).

Зураг 6. Биедээ авч явж буй бэлэн мөнгөний дундаж хэмжээ, төгрөгөөр

а) Байршил, насны бүлэг, хүйс, боловсролын байдлаар



б) Ажил эрхлэлт, орлогын бүлгээр




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Зураг 7-д тухайн өдөр нэмж бэлэн мөнгө авсан 510 иргэдийн бэлэн мөнгөний хэмжээний тархалтыг харуулав. Тархалт нь баруун тийш хазайсан бөгөөд медиан утга 20.0 мянган төгрөг, дундаж утга 33.1 мянган төгрөг байна. Энэ нь ихэнх иргэд харьцангуй бага хэмжээний бэлэн мөнгийг давтамжтайгаар нэмж авч байгаа хэдий ч цөөн тооны иргэд багагүй бэлэн мөнгө нэмж авдгаас шалтгаалан нийт дундаж утга өсжээ (Зураг 7.а). Тухайн өдөр нэмж авсан бэлэн мөнгөний хэмжээ нь иргэдийн богино хугацааны бэлэн мөнгөний эрэлтийг илэрхийлэх урсгал (flow) үзүүлэлт бөгөөд АТМ ашиглалт, бэлэн мөнгөний нийлүүлэлтийн төлөвлөлтөд ач холбогдолтой.

Өдрийн эхэнд авч явж буй бэлэн мөнгөний хэмжээний тархалттай харьцуулахад тухайн өдөр нэмж авсан бэлэн мөнгөний медиан өндөр байгаа нь иргэд өдөр тутмын хэрэглээгээ бэлэн мөнгөөр гүйцэтгэхдээ шаардлагатай үед нэмж авах зан төлөв давамгайлж байгааг харуулж байна.

а) Тархалт




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Нэмж авсан бэлэн мөнгөний хэмжээ нь байршил, нас, боловсрол, ажил эрхлэлт, орлогын түвшнээс хамааран ялгаатай байгаа бөгөөд бүх бүлэгт дундаж утга медианаас өндөр байгаа нь бэлэн мөнгө авдаг хэмжээ жигд бус байгааг илтгэнэ. Ялангуяа ахмад насныхан, тэтгэвэрт болон өндөр орлоготой иргэдийн дунд бэлэн мөнгөний хамаарал харьцангуй өргөн хүрээнд байна (Зураг 8).

Зураг 8.в-д тухайн өдөр нэмж авсан бэлэн мөнгөний эх үүсвэрийн ашиглалтын давтамж болон авсан мөнгөний дундаж, медиан дүнг хамтад нь харуулав. Иргэдийн хувьд АТМ болон КИОСК нь өндөр давтамжтай, дунд зэргийн дүнтэй бэлэн мөнгө авдаг үндсэн суваг бол хувь хүн, байгууллага болон бусад эх үүсвэрүүд нь давтамж багатай ч харьцангуй их хэмжээний бэлэн мөнгөний урсгалыг бүрдүүлж байна. Түүнчлэн төлбөр тооцооны явцад хариултаар авсан бэлэн мөнгө нь давтамж харьцангуй өндөр боловч медиан дүн хамгийн бага байгаа нь жижиг, тохиолдлын шинжтэй урсгал давамгайлж байгааг харуулж байна.


Зураг 8. Нэмж авсан бэлэн мөнгөний дундаж хэмжээ, төгрөгөөр
 а) Байршил, насны бүлэг, хүйс, боловсролын байдлаар



б) Ажил эрхлэлт, орлогын бүлгээр



в) Эх үүсвэрийн төрлөөр болон давтамж



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Шигтгээ 2. Бэлэн мөнгө, төлбөр тооцооны хандлага

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 1,2 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад 1.7 дахин нэмэгдээд байна (Зураг 9). Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд технологийн хурдацтай дэвшилтэй уялдан картын гүйлгээ, шилжүүлэг, ухаалаг хэтэвч зэрэг бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, улмаар бэлэн мөнгөөр хийгдэх гүйлгээний эзлэх хувь мэдэгдэхүйц буураад байна. Тухайлбал, 2020 оны эхэнд нийт төлбөр тооцооны тоо хэмжээний 20%, үнийн дүнгийн 50%-ийг бэлэн мөнгө эзэлж байсан бол 2025 онд тоо хэмжээний 7%, үнийн дүнгийн 23% болж буурчээ. Харин, бэлэн мөнгөөр хийгдэж буй гүйлгээний дундаж дүн нь бэлэн бус төлбөрийн дунджаас 4 дахин өндөр дүнтэй байна (Зураг 12).

Зураг 9. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө




Зураг 10. Төхөөрөмж дээр хийгдсэн гүйлгээ, тоогоор



Зураг 11. Төхөөрөмж дээр хийгдсэн гүйлгээ, үнийн дүнгээр



Зураг 12. Төхөөрөмж дээр хийгдсэн гүйлгээний дундаж




Тайлбар: АТМ, СDM, СRM зэрэг зөвхөн сүлжээний төхөөрөмжийн гүйлгээ болно. Өөрөөр хэлбэл, иргэд болон аж ахуйн нэгжүүд хоорондын бэлнээр хийсэн төлбөр тооцоо ороогүй болно.

Эх сурвалж: Монголбанк, "Бюллетень", "Төлбөрийн системийн тайлан"

2.4. Төлбөр тооцоо

Тус түүвэр судалгаанд оролцсон нийт иргэдийн 83% нь тухайн өдөр ямар нэгэн төлбөр тооцоо хийсэн бөгөөд тэдгээрийн 2,618 удаагийн төлбөр тооцооны мэдээлэл бүртгэгдсэн. Өөрөөр хэлбэл, иргэд өдөрт дунджаар 1.6 удаагийн төлбөр тооцоо хийдэг байна. Эдгээр мэдээлэлд үндэслэн тухайн өдрийн туршид хийсэн нийт төлбөр тооцооны дүнгийн тархалтыг Зураг 13-т харуулав. Нийт төлбөр тооцооны дүнгийн медиан 30.0 мянган төгрөг, дундаж 54.8 мянган төгрөг байна. Тархалтын ихэнх ажиглалтууд 50 мянган төгрөгөөс доош хэсэгт төвлөрдөг буюу иргэдийн өдөр тутмын төлбөр тооцооны дийлэнх нь бага, дунд дүнтэй гүйлгээнээс бүрдэж байна. Харин баруун талын урт “сүүл” хэсэгт ажиглагдах цөөн тооны гүйлгээ нь 100 мянган төгрөгөөс дээш, зарим тохиолдолд 300–400 мянган төгрөгөөс дээш хүрч байгаа нь нийт тархалтын асимметрийг бий болгож байна. Иймд энэхүү тархалтад медиан үзүүлэлт нь иргэдийн “ердийн” төлбөрийн хэмжээг илүү бодитой илэрхийлж байгаа бол дундаж үзүүлэлт нь өндөр дүнтэй гүйлгээний нөлөөг шингээсэн, нийт төлбөрийн ачааллыг илэрхийлэхэд илүү тохиромжтой байна.

Зураг 13. Төлбөр тооцооны үнийн дүнгийн тархалт, төгрөгөөр



Байршлаар авч үзвэл орон нутагт нэг өдрийн дундаж төлбөрийн дүн Улаанбаатараас өндөр байгаа нь хэрэглээний бүтэц, төлбөрийн хэрэгслийн хүртээмжтэй холбоотой байж болох юм. Насны бүлгээр ахих тусам төлбөрийн дундаж дүн нэмэгдэх хандлага ажиглагдаж, ялангуяа 36 ба түүнээс дээш насны бүлгүүдэд дундаж төлбөр харьцангуй өндөр байна. Хүйсийн хувьд ялгаа харьцангуй бага боловч эмэгтэйчүүдийн медиан дүн арай өндөр байгаа нь өдөр тутмын тогтмол хэрэглээтэй

холбоотой байж болзошгүй. Түр болон ажилгүй иргэдийн хувьд төлбөрийн дундаж бага байгаа бол ажил эрхэлж буй хүмүүсийн хувьд төлбөр тооцооны ялгаа төдийлөн ажиглагдсангүй. Харин орлого өсөхийн хэрээр төлбөрийн дундаж дүн нэмэгдэх хандлагатай байна.

Төлбөрийн хэрэгслээр авч үзвэл бэлэн мөнгө нь төлбөрийн тооны хувьд тодорхой байр суурь эзэлж байгаа ч үнийн дүнгийн хувьд харьцангуй бага байна. Харин карт болон гар утсаар хийсэн онлайн төлбөрүүд нь нийт үнийн дүнд давамгайлж, дундаж төлбөрийн дүн харьцангуй өндөр байна.

Шигтгээ 3. Монгол Улсын төлбөрийн систем

Төлбөрийн систем нь орчин үеийн санхүүгийн системийн салшгүй хэсэг бөгөөд хувь хүн, бизнес, санхүүгийн байгууллагуудын хооронд мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх үйл явцыг хөнгөвчлөхөд голлох үүрэг гүйцэтгэдэг (Shang ба Chiu 2022). Тэр ч утгаараа Монгол Улсын төлбөрийн систем нь эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн салбарын хөгжлийг дэмжихэд чухал үүрэгтэй дэд бүтэц бөгөөд банк санхүүгийн салбар дахь төлбөр тооцоог тасралтгүй, шуурхай, найдвартай явуулах замаар эдийн засгийн мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангадаг.

Манай улсын төлбөрийн систем нь их дүнтэй төлбөр тооцооны систем (RTGS), бага дүнтэй, жижиглэнгийн төлбөрийн систем (ACH), төлбөрийн картын нэгдсэн сүлжээ гэсэн үндсэн гурван сувгаар дамждаг (Зураг 14). Бүх банк, том финтек байгууллагууд өөрийн гэсэн интернэт болон мобайл төлбөрийн шийдэл, аппликейшнтэй бөгөөд төлбөрийн системийн хөгжилтэй уялдан хэрэглэгчид цахим сувгийг ашиглан өдөр шөнө, хөдөө орон нутаг, цаг хугацаа, орон зай хамаарахгүйгээр төлбөр тооцоо хийх боломжтой байдаг.

Зураг 14. Төлбөрийн систем




Эх сурвалж: Монголбанк

Мөн манай улсын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ нь нийт 19 оролцогчтой (12 банк, 7 финтек байгууллага) холбогдсон байдаг бөгөөд харилцан нэгнийхээ картыг 100 хувь, чөлөөтэй хүлээж авдаг. 2024 оноос эхлэн соронзон туузтай картын хэрэглээг халж, бүх төлбөрийн карт, ПОС, АТМ төхөөрөмжүүд EMV чип технологи руу бүрэн шилжээд байна. Энэхүү шилжилтийн хүрээнд NFC буюу төлбөрийн картыг зайнаас унших “contactless” технологийг хамт нэвтрүүлсэн бөгөөд зуун мянган төгрөг буюу 30 орчим ам.доллараас бага дүнтэй “contactless” гүйлгээнд ПИН код, гарын үсэг гэх мэт баталгаажуулалт шаардахгүй болсон. Улмаар, төлбөр тооцоо хийхэд “5 секунд” л хангалттай болжээ.

Түүнчлэн 2024-2025 онуудад “Apple Pay”, “Google Pay” зэрэг олон улсын төлбөр тооцооны үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн нь түрийвч, биет карт бүр бэлэн мөнгө авч явах шаардлагагүй болж, төлбөр тооцоо хийхэд улам хялбар, шуурхай болгож байна (Зураг 15).


Зураг 15. Төлбөрийн системийн түүхэн хөгжил




Мөн төлбөрийн зориулалтаар авч үзвэл томоохон худалдан авалт, үйлчилгээ, тогтмол төлбөрүүд (түрээс, үйлчилгээний хураамж гэх мэт) нь харьцангуй өндөр дундаж дүнтэй байгаа бол өдөр тутмын жижиг хэрэглээ (хоол, жижиг худалдан авалт) нь бага дүнтэй, олон давтамжтай гүйлгээнээс бүрдэж байна. (Зураг 16).

Зураг 16. Төлбөр тооцооны дундаж хэмжээ, төгрөгөөр


а) Байршил, насны бүлэг, хүйс, боловсролын байдлаар




б) Ажил эрхлэлт, орлогын бүлгээр



в) Төлбөрийн хэрэгслээр, төлбөр тооцооны тоо, дүнд эзлэх хувь



г) Зориулалт, байршлаар, төлбөр тооцооны тоо, дүнд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Орон нутагт бэлэн мөнгөөр хийсэн төлбөрийн дундаж болон медиан дүн Улаанбаатараас өндөр байгаа нь орон нутагт бэлэн мөнгөний хамаарал илүү өндөр хэвээр байгааг харуулж байна. Улаанбаатарт бэлэн төлбөрийн медиан харьцангуй бага байгаа нь дижитал төлбөрийн өргөн хэрэглээтэй уялдаж байна. Нас ахих тусам бэлэн мөнгөөр хийсэн төлбөрийн дундаж дүн өсөх хандлага ажиглагдаж, ялангуяа 46 ба түүнээс дээш насны иргэдийн хувьд бэлэн төлбөрийн медиан болон дундаж аль аль нь өндөр байна. Харин 18–25 насны бүлэгт бэлэн төлбөрийн дүн хамгийн бага байгаа нь залуу үеийн дижитал төлбөрийн хэрэгсэлд илүү шилжсэн зан төлөвийг илтгэнэ.

Хүйсийн хувьд бэлэн төлбөрийн дундаж дүн ойролцоо байгаа боловч медиан утга эмэгтэйчүүдийн хувьд арай өндөр байгаа нь өдөр тутмын жижиг, тогтмол хэрэглээтэй холбоотой байж болзошгүй. Ерөнхийдөө бэлэн төлбөрийн зан төлөв хүйсийн ялгаанаас илүү нас, орлогын түвшнээс хамаарч байна. Боловсролын түвшинд бэлэн мөнгөний хэрэглээний ялгаа харьцангуй бага байна. Тэтгэвэрт гарсан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бэлэн төлбөрийн дундаж дүн бусад бүлгүүдээс өндөр байгаа нь тэдний төлбөрийн зан төлөвт бэлэн мөнгө чухал байр суурь эзэлсээр байгааг илтгэнэ. Харин төрийн болон хувийн хэвшлийн ажилтнуудын хувьд бэлэн төлбөрийн медиан харьцангуй доогуур байна.

Орлогын түвшин өсөхийн хэрээр бэлэн мөнгөөр хийсэн төлбөрийн дундаж дүн нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа ч медиан өсөлт харьцангуй бага байна. Энэ нь өндөр орлоготой бүлэгт цөөн тооны их хэмжээний бэлэн гүйлгээ байгааг, харин ихэнх гүйлгээ бэлэн бус хэлбэрт шилжсэнийг илтгэнэ. Бэлэн мөнгө нь ихэвчлэн өдөр тутмын жижиг хэрэглээ (хоол, жижиг худалдан авалт, үйлчилгээ)-д төвлөрч байгаа боловч тогтмол төлбөр, тодорхой үйлчилгээний зарим

тохиолдолд харьцангуй өндөр дүнтэй бэлэн гүйлгээ хийгдэж байна. Гэсэн хэдий ч эдгээр нь давтамжийн хувьд бага бөгөөд нийт тархалтын “сүүл” хэсгийг бүрдүүлж байна (Зураг 17).

Зураг 17. Бэлнээр хийсэн төлбөр тооцооны дундаж хэмжээ

а) Байршил, насны бүлэг, хүйс, боловсролын байдлаар



б) Ажил эрхлэлт, орлогын бүлгээр



в) Зориулалт, байршлаар, төлбөр тооцооны тоо, дүнд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

2.5. Төлбөрийн хэрэгслийн ашиглалт

Нийт төлбөр тооцооны тоонд эзлэх хувиар авч үзвэл, бэлэн бус төлбөрүүд (карт, гар утас гэх мэт) нийтдээ давамгайлж байгаа боловч нас, орлого, ажил эрхлэлтийн бүлгүүдийн хооронд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Төлбөр тооцооны тоонд эзлэх хувиар харахад иргэдийн 73% нь бэлэн бус, 27% нь бэлэн мөнгөөр төлбөрөө гүйцэтгэж байна. Үүнээс 37% нь онлайн шилжүүлэг, цахим хэтэвч, мобайл банк зэргээр гар утас ашиглан төлбөрөө хийдэг бол 34% нь биет карт ашиглаж байна. Ялангуяа залуу, өндөр орлоготой иргэдийн дунд дижитал бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ өндөр хэвээр байгаа бол ахмад болон тэтгэвэрийн иргэдийн хувьд бэлэн мөнгөний хэрэглээ харьцангуй өндөр байна (Зураг 18).

Зураг 18. Төлбөрийн хэрэгслийн ашиглалт, тоонд эзлэх хувиар

а) Байршил, насны бүлэг, хүйс, боловсролын байдлаар



б) Ажил эрхлэлт, орлогын бүлгээр




Эх сурвалж: Монголбанк, "Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа" (2025)

Төлбөр тооцооны дүнд эзлэх хувиар харахад залуу насныхны хувьд их дүнтэй төлбөрүүдийг бэлэн бус төлбөрийн хэрэгслээр гүйцэтгэж байгаа

бол ахмад насныхны дунд бэлэн болон картын төлбөрийн үнийн дүн харьцангуй өндөр байна. Нийт шилжүүлгийн дүнгийн 82% нь бэлэн бус (үүнээс 47% нь гар утас, 33% биет карт), 18% нь бэлэн мөнгөөр төлбөрөө гүйцэтгэж байна. (Зураг 19). Төлбөр тооцооны тооны хувьд бэлэн мөнгө тодорхой бүлгүүдэд чухал хэвээр байгаа боловч үнийн дүнгийн хувьд дижитал төлбөрүүд илт давамгайлж байна.

Зураг 19. Төлбөрийн хэрэгслийн ашиглалт, үнийн дүнд эзлэх хувиар

а) Байршил, насны бүлэг, хүйс, боловсролын байдлаар



б) Ажил эрхлэлт, орлогын бүлгээр




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)


Төлбөр тооцооны тооны бүтэц нь иргэдийн өдөр тутмын хэрэглээний зан төлөвийг, харин үнийн дүнгийн бүтэц нь эдийн засгийн ач холбогдол бүхий их дүнтэй гүйлгээг илүү тодорхой харуулж байна. Энэ хоёрын зөрүү нь бэлэн мөнгө жижиг гүйлгээнд, харин бэлэн бус төлбөрүүд их дүнтэй гүйлгээнд төвлөрч байгааг баталгаажуулж байна (Зураг 20).

Зураг 20. Төлбөрийн хэрэгслийн ашиглалт, гүйлгээний зориулалт, байршлаар

а) Төлбөрийн тооцооны тоонд эзлэх хувиар



б) Төлбөрийн тооцооны үнийн дүнд элэх хувиар



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Мөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн төлбөрийн хэрэгсэл ашигладаг давтамжийг авч үзвэл биет карт болон банкны аппликейшнийг өдөр тутамдаа тогтмол ашиглаж байна. Тодруулбал, биет картыг иргэдийн 55%, банкны аппликейшнийг 61% нь өдөр бүр хэрэглэдэг бол эдгээр хэрэгслийг огт ашигладаггүй иргэдийн эзлэх хувь харьцангуй бага буюу харгалзан 8%, 11% байна. Харин бэлэн мөнгө хэрэглэдэг давтамжийг авч үзвэл судалгаанд оролцсон иргэдийн 43% нь сард хэдхэн удаа ашигладаг бөгөөд 15% нь огт ашигладаггүй байна. Цахим хэтэвч болон мобайл банкны⁶ хэрэглээг авч үзвэл өдөр тутмын хэрэглээ харьцангуй бага, харин огт ашигладаггүй иргэдийн эзлэх хувь өндөр бөгөөд цахим хэтэвчийг 49%, мобайл банкныг 65% нь огт ашигладаггүй байна. Түүнчлэн одоо аваад дараа төлөх үйлчилгээ болон Apple pay зэрэг ухаалаг төхөөрөмж нь хамгийн бага хэрэглээтэй төлбөрийн хэрэгслүүдэд тооцогдож байгаа бөгөөд судалгаанд

⁶ Бүх төрлийн гар утаснаас тусгай дугаарт залгах эсвэл мессеж илгээх байдлаар гүйлгээ хийх үйлчилгээний төрөл

оролцогчдын 67% нь одоо аваад дараа төлөх үйлчилгээг огт ашигладаггүй байна. Үүнээс дүгнэхэд уламжлалт төлбөрийн хэрэгслүүд болох биет карт, банкны аппликейшн нь иргэдийн өдөр тутмын хэрэглээнд давамгайл хэвээр байгаа бол харьцангуй шинэ дижитал төлбөрийн хэрэгслүүдийн хэрэглээ одоогоор хязгаарлагдмал хүрээнд байна (Зураг 21).


Зураг 21. Төлбөрийн хэрэгсэл ашигладаг давтамж



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Тус судалгаагаар бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх нь бусад төлбөрийн хэрэгслээс ямар давуу тал байдаг талаар иргэдийн саналыг тодрууллаа. Бэлэн мөнгийг төлбөр тооцоонд ашигладаг иргэдийн хувьд бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхэд бусад төлбөрийн хэрэгслээс илүү хурдан (21%), төлбөр шууд хийгддэг (16%), илүү хялбар (14%) гэсэн үндсэн шалтгаанаар бэлэн мөнгийг ашигладаг байна. Мөн хувийн нууцыг илүү сайн хамгаалдаг (13%) болон бэлэн мөнгийг илүү олон газарт хүлээн авдаг (13%) нь удаах шалтгаан болдог байна (Зураг 22).

Зураг 22. Төлбөр тооцоог бэлэн мөнгөөр хийх давуу тал



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)


2.6. Бэлэн мөнгөний хэрэглээ

Иргэдийн хувьд өдөр тутамдаа дунджаар 10,000 төгрөгийг өдрийн эхэнд биедээ авч явдаг бөгөөд 20,000 төгрөгийг дийлэнх тохиолдолд АТМ, 25


КИОСК зэрэг бэлэн мөнгөний машинаас авч, улмаар өдрийн туршид 16,000 төгрөгийг хүнсний дэлгүүр, зах худалдааны төв зэрэг газруудад зарцуулж, улмаар өдрийн эцэст ойролцоогоор 14,000 төгрөгтэй дүйцэх бэлэн мөнгө үлддэг байна (Зураг 23).

Мөн өдрийн туршид нэмж авсан бэлэн мөнгө нь өдрийн эхэнд байх мөнгөнөөс бага зэрэг илүү байгаа нь иргэд бэлэн мөнгөний хэрэглээгээ урьдчилан төлөвлөхөөс илүү тухайн нөхцөлд нийцүүлэн нэмж авдаг болохыг харуулна. Өөрөөр хэлбэл, бэлэн мөнгө биедээ авч явахаас илүүтэйгээр шаардлагатай тохиолдолд нэмж бэлэн мөнгө авч үлдсэн дүнг хадгалж үлддэг байна. Түүнчлэн өдөр тутамдаа авч явж буй бэлэн мөнгө, бэлнээр зарцуулдаг болон үлдэж буй бэлэн мөнгөний дундаж хэмжээ нь гүйлгээнд хүчин төгөлдөр дэвсгэртүүдийн нэрлэсэн дүнгээс бага байх тул 1,000, 5,000, 10,000-т зэрэг дэвсгэртүүд илүү өргөнөөр хэрэглэгддэг байж болзошгүй юм.

Зураг 23. Иргэдийн бэлэн мөнгөний дундаж хэрэглээ, төгрөгөөр
а) Дундаж дүнгээр



б) Медиан дүнгээр



Эх сурвалж: Монголбанк, "Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа" (2025)

3. АЖ АХУЙН НЭГЖИЙН БЭЛЭН МӨНГӨНИЙН ХЭРЭГЛЭЭ

3.1. Түүвэрлэлт

Аж ахуйн нэгжүүдийн судалгааны хамрах хүрээг тодорхойлохдоо улсын хэрэглээний үнийн индексийн 13 ерөнхий бүлгийн хувьд тэдгээр бараа, үйлчилгээг үйлдвэрлэдэг, худалдаалдаг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад тус тус харгалзууллаа. Ингэхдээ улсын хэрэглээний сагсны бүлэгт өндөр жин эзлэх хэдий ч тогтмол бус хэрэглэгддэг, тухайн бүлэгт хамаарах аж ахуйн нэгжүүдийн тоо цөөн, ижил шинж чанартай зэрэг хүчин зүйлсийг харгалзан зарим тохируулга хийв. Тодруулбал, тээврийн үйлчилгээний бүлэгт хамаарах тээврийн

хэрэгслийн худалдан авалтын 6.9%, тээврийн хэрэгслийн шатах, тослох материалын 7.5%, мэдээлэл холбооны үйлчилгээний 4.3%, дээд боловсролын үйлчилгээний 3.3%-ийг тус тус харгалзах бүлгийн жингээс хорогдуулж тооцлоо.

Ийнхүү харгалзуулахад Хөдөө аж ахуй, Уул уурхай, олборлолт, Боловсруулах үйлдвэрлэл, Барилга, Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, Мэргэжлийн болон шинжлэх ухааны үйл ажиллагаа, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа болон Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газар гэсэн 11 эдийн засгийн үйл ажиллагааны салбарын аж ахуйн нэгжүүдийг хасаж тооцов. Өөрөөр хэлбэл, хэрэглээний барааны сагсны гол хэсгийг бүрдүүлдэг бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэгч, худалдаалагч аж ахуйн нэгжүүдийг түүвэр судалгааны хүрээгээр сонгов. Хүснэгт 2-с харахад Бөөний болон жижиглэн худалдааны салбарын төлөөллийг голлон хамруулах шаардлагатай нь харагдаж байна.

Хүснэгт 2. Улсын хэрэглээний сагсны бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийг салбаруудад харгалзуулсан байдал

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлэг	Хувийн жин	Эдийн засгийн үйл ажиллагааны харгалзах салбар
1	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	26.7%	Бөөний болон жижиглэн худалдаа
2	Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	1.0%	Бөөний болон жижиглэн худалдаа
3	Хувцас, бөс бараа, гутал	12.9%	Бөөний болон жижиглэн худалдаа
4	Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	4.8%	Ус хангамж; Цахилгаан, хий, уур, агааржуулалт
5	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.8%	Бөөний болон жижиглэн худалдаа
6	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3%	Бөөний болон жижиглэн худалдаа
7	Тээвэр	2.4%	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа
8	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.5%	Мэдээлэл, холбоо
9	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.5%	Урлаг, үзвэр, тоглоом наадам
10	Боловсролын үйлчилгээ	2.0%	Боловсрол
11	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.4%	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
12	Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.4%	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа
13	Бусад бараа, үйлчилгээ	5.6%	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
Нийт		73.4%	

Энэхүү түүврийн хүрээгээр тооцоход 2025 оны 2 дугаар улирлын байдлаар **70,129** аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна. Аж ахуйн нэгжүүдийн салбарын болон байршлын ялгаатай төлөөллийг хангахын тулд орон нутаг, Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн тоог харгалзан аймаг бүрээс 15, Улаанбаатар хотоос 230 орчим аж ахуйн нэгжийг судалгаанд хамруулж, нийт **540** судалгаа авлаа.

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн тоо

Аймаг	Үйл ажиллагаа явуулж буй ААН			Судалгаанд хамрагдсан ААН		
	Тоо	Хувийн жин	Судалгаанд оролцсон	Хувийн жин	Нийтэд эзлэх хувь	
1	Архангай	807	1.2%	15	5%	1.9%
2	Баян-Өлгий	1,003	1.4%	15	5%	1.5%
3	Баянхонгор	963	1.4%	15	5%	1.6%
4	Булган	614	0.9%	15	5%	2.4%
5	Говь-Алтай	515	0.7%	15	5%	2.9%
6	Говьсүмбэр	240	0.3%	15	5%	6.3%
7	Дархан-Уул	1,574	2.2%	15	5%	1.0%
8	Дорноговь	948	1.4%	15	5%	1.6%
9	Дорнод	1,156	1.6%	15	5%	1.3%
10	Дундговь	529	0.8%	15	5%	2.8%
11	Завхан	974	1.4%	15	5%	1.5%
12	Орхон	1,937	2.8%	15	5%	0.8%
13	Өвөрхангай	882	1.3%	15	5%	1.7%
14	Өмнөговь	1,853	2.6%	15	5%	0.8%
15	Сүхбаатар	571	0.8%	15	5%	2.6%
16	Сэлэнгэ	1,167	1.7%	15	5%	1.3%
17	Төв	622	0.9%	11	4%	1.8%
18	Увс	919	1.3%	15	5%	1.6%
19	Ховд	1,641	2.3%	15	5%	0.9%
20	Хөвсгөл	1,065	1.5%	15	5%	1.4%
21	Хэнтий	772	1.1%	15	5%	1.9%
	Орон нутаг	20,752	29.6%	311	58%	1.5%
	Улаанбаатар	49,377	70.4%	229	42%	0.5%
	Нийт	70,129	100%	540	100%	0.8%

Эх сурвалж: ҮСХ, Судлаачийн тооцоолол

3.2. Түүвэр судалгааны ерөнхий мэдээлэл

Тус түүвэр судалгааны мэдээллийг удирдлага, холбогдох албан тушаалтантай⁷ утсаар болон биечлэн ярилцлага хийх, онлайн асуулгын аргаар цуглууллаа. Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийг байршлаар авч үзвэл нийт оролцогчдын 58%-ийг Улаанбаатар хот, 42%-ийг орон нутгийн бизнес эрхлэгч ААН-үүд эзэлж байна. Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн хариуцлагын хэлбэрийг авч үзвэл дийлэнх нь буюу 66% нь ХХК болон ХК, 28% нь хувиараа бизнес эрхлэгч, 2% нь ТӨҮГ

⁷ ААН-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх бүрэн боломжтой удирдах албан тушаалтнууд

болон 1% нь ОНӨҮГ, ТББ, нөхөрлөл, хоршоо хэлбэрээр тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Мөн судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь буюу 60% нь бөөний болон жижиглэн худалдаа, 23% нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны чиглэлийн бизнес эрхлэгчид байна. Худалдаа эрхлэгчдийн хувьд дийлэнх буюу 52% нь хүнсний дэлгүүр, тус бүр 7% нь эмийн сан, хувцас бөс бараа, гутлын худалдаа, мөн тус бүр 6% нь гэр ахуйн бараа болон барилгын материалын худалдааны бизнес эрхлэгчид тус тус бүрдүүлж байна (Зураг 24).

Зураг 24. Судалгаанд оролцогч ААН-үүдийн мэдээлэл

а) Байршил



б) Хариуцлагын хэлбэр



в) Голлох үйл ажиллагаа



г) Худалдаалах бүтээгдэхүүний нэр төрөл, байршил



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 72% нь 10 хүртэлх тооны ажилчинтай бол 21% нь 10-49, 7% нь 50-с дээш ажилчинтай байна. Тус

ААН-үүдийн 39% нь жилд 50 сая хүртэлх, 31% нь 51-300 сая, 13% нь 301 саяас-1.0 тэрбум, тус тус 9% нь 1.0-2.5 тэрбум, 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой байна. Мөн аж ахуйн нэгжүүдийн 14% нь эхний 2 жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа бол 21% нь 3-5 жил, 26% нь 6-10, 14% нь 11-15 дахь жилдээ ажиллаж байна. Харин тус тус 13% нь 16-20 жил, 21-с дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхэлж байна (Зураг 25).

Зураг 25. Судалгаанд оролцогч ААН-үүдийн мэдээлэл


а) Ажиллагсдын тоо



б) Борлуулалтын орлого



ё) Туршлага




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч талаас харахад иргэдийн төлбөр тооцоо хамгийн ихээр хийгддэг буюу үйлчлүүлдэг хэсэг судалгаанд хамрагдсан нь төлбөр тооцоо, цаашилбал бэлэн мөнгөтэй холбоотой хэрэглээний зан төлөвийг илэрхийлэх боломжтой түүвэр бүрдсэн гэж үзэж байна. Нөгөө талаас, төлбөр тооцоо хүлээн зөвшөөрөх, бэлэн мөнгөний хэрэглээний зан төлөв нь байршил, хариуцлагын хэлбэр, бизнесийн цар хүрээ (ажиллагсдын тоо, борлуулалтын орлого), үйл ажиллагааны салбар болон худалдан борлуулж буй бүтээгдэхүүний нэр төрөл, байршлаас ихээхэн хамаарах боломжтой тул цаашдын бүх үзүүлэлтүүдэд дээрх шинж чанаруудыг бүрэн тусгалаа.

3.3. Төлбөрийн хэрэгслүүдийг хүлээн зөвшөөрдөг байдал

Уг судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид үйл ажиллагаандаа ямар төлбөрийн хэрэгслийг хүлээн зөвшөөрч, ашиглах бололцоог хангадаг талаар судалж үзлээ. Үүнд нийт ААН-үүдийн 97% нь банкны аппликейшнийг хүлээн зөвшөөрдөг бол 86% нь биет карт, 84% нь бэлэн мөнгийг хүлээн зөвшөөрч хэрэглэгч, харилцагчидтай төлбөр тооцоог гүйцэтгэдэг байна. Виртуал карт, Monpay, Hipay, CU pay, Toki, DiGi pay, Social pay гэх мэт цахим хэтэвчүүд, Apple pay, Google Pay зэрэг ухаалаг төхөөрөмж ашиглах төлбөр тооцооны төлбөрийн хэрэгслийг ААН-үүдийн 36% нь ашиглахыг зөвшөөрдөг бол Storepay, LendDy, Simple buy зэрэг одоо аваад дараа төлөх үйлчилгээг ААН-үүдийн 15% нь хүлээн зөвшөөрч төлбөр тооцоогоо гүйцэтгэж байна (Зураг 26).


Зураг 26. Төлбөрийн хэрэгслийг хүлээн зөвшөөрдөг эсэх



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь төлбөр тооцоондоо бэлэн мөнгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд нийт дүнгээрээ 80–90 орчим хувьтай байна. Энэ хандлага нь байршил, ажиллагсдын тоо, борлуулалтын орлогоос үл хамааран харьцангуй тогтвортой өндөр байгаа нь бэлэн мөнгө нь худалдаа эрхлэгчдийн хувьд зайлшгүй хүлээн зөвшөөрөх хэрэгсэл хэвээр байгааг илтгэнэ. Ялангуяа хүнсний дэлгүүр, жижиглэн худалдаа, зах, мини маркет зэрэг өдөр тутмын хэрэглээ давамгайлсан салбар, байршлуудад бараг бүх ААН бэлэн мөнгө хүлээн авдаг байна. Харин зарим үйлчилгээний салбарт бэлэн мөнгө хүлээн зөвшөөрөх хувь харьцангуй бага байгаа нь төлбөрийн хэрэгслийн сонголт нь бизнесийн онцлогоос хамаарч ялгаатай байгааг харуулж байна (Зураг 27). Ерөнхий утгаараа энэхүү үр дүн нь бэлэн мөнгийг төлбөрийн системээс богино хугацаанд орлуулах боломж хязгаарлагдмал байгааг илтгэнэ.

Зураг 28. Төлбөр тооцоог бэлэн мөнгөөр хийх давуу тал




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Харин бэлэн мөнгийг төлбөр тооцоондоо хүлээн зөвшөөрч ашигладаггүй ААН-үүдийн гол шалтгаан нь хариулт мөнгө байнга байлгах нь төвөгтэй байдаг (40%) гэж үзжээ. Мөн ашиглахад хугацаа их шаарддаг гэж 14% нь үзсэн бол үйлчлүүлэгчид бэлэн мөнгийг хэрэглэдэггүй гэж 13% нь, аюулгүй байдлын эрсдэлтэй гэж 9% нь хариулжээ. Эдгээр ААН-үүдийн тус тус 33% нь 1 жил хүртэл хугацааны өмнөөс, 2-5 жилийн өмнөөс бэлэн мөнгийг ашиглахаа больсон байна (Зураг 29).

Зураг 29. Бэлэн мөнгө ашигладаггүй ААН

а) Бэлэн мөнгө ашигладаггүй шалтгаан



б) Бэлэн мөнгө ашиглахаа больсон хугацаа




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

3.4. Бэлэн мөнгө хэрэглэх зан төлөв

Түүвэр судалгаанд хамрагдсан худалдаа эрхлэгчид болон ААН-үүдийн 32% буюу 171 нь кассанд бэлэн мөнгө байлгадаггүй болон хариулахаас татгалзсан тул бэлэн мөнгөний мэдээлэл авч чадаагүй. Харин үлдсэн 369 худалдаа эрхлэгч, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд үндэслэн касс дах бэлэн мөнгөний өдрийн дундаж үлдэгдлийг тооцлоо.

Зураг 30-д худалдаа эрхлэгчдийн кассанд хадгалж буй бэлэн мөнгөний тархалтыг харууллаа. Тархалт нь баруун тийш хазайсан бөгөөд медиан утга 500.0 мянган төгрөг, дундаж утга 2.05 сая төгрөг байна. Энэхүү тархалтын хэлбэр нь худалдаа эрхлэгчдийн бэлэн мөнгөний нөөц жигд бус, бизнесийн хэмжээ, борлуулалтын эргэлт, байршил, мөн банкны үйлчилгээний хүртээмжээс ихээхэн хамаарч байгааг илтгэнэ. Ийм нөхцөлд дундаж үзүүлэлт нь нийт тархалтыг хэтрүүлэн илэрхийлэх хандлагатай тул кассанд хадгалагдаж буй бэлэн мөнгөний хэмжээг тодорхойлоход медиан үзүүлэлт илүү төлөөлөх ач холбогдолтой байна.

Зураг 30. Касс дах бэлэн мөнгөний хэмжээний тархалт, мянган төгрөг



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Худалдаа эрхлэгчдийн кассанд хадгалж буй бэлэн мөнгөний хэмжээ бизнесийн шинж чанараас хамааран мэдэгдэхүйц ялгаатай байна. Тухайлбал, байршлаас үл хамааран касс дах бэлэн мөнгөний дундаж ойролцоо боловч медиан утга Улаанбаатарт орон нутгаас бага зэрэг бага буюу 400.0 мянган төгрөг байна. Түүнчлэн хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болон хувьцаат компани (ХК)-ууд нь кассандаа дунджаар 2.5 сая төгрөгтэй байгаа бол хувиараа хөдөлмөр эрхлэгч худалдаачид 395 мянган төгрөгтэй байна. Тус худалдаа эрхлэгчид нь бизнесийн үйл ажиллагаандаа 200.0 мянга (медиан утга) орчим төгрөгийг дийлэнхдээ байлгадаг байна.

Мөн борлуулалтын орлого, ажиллагсдын тоо ихсэхийн хэрээр кассанд байлгах бэлэн мөнгөний дундаж хэмжээ нэмэгдэх хандлагатай боловч медиан хэмжээ харьцангуй тогтвортой байгаа нь ихэнх худалдаа эрхлэгчид эргэлтийн зориулалттай бага хэмжээний бэлэн мөнгө хадгалж байгааг харуулна. Салбар болон худалдааны байршлаар авч

үзвэл хүнс, жижиглэн худалдаа зэрэг өдөр тутмын хэрэглээ давамгайлсан байршлуудад кассын бэлэн мөнгө бага төвлөрч, харин удаан эдэлгээт бараа, өндөр дүнтэй худалдаанд цөөн боловч их хэмжээний кассын нөөц ажиглагдаж байна. Иймд касс дах бэлэн мөнгөний ялгаа нь гүйлгээний хэмжээ бус, харин эрсдэл, хариулт мөнгө болон бэлэн мөнгөний удирдлагын хэрэгцээтэй илүү уялдаатай байна (Зураг 31).

Зураг 31. Касс дах бэлэн мөнгөний дундаж хэмжээ, мянган төгрөг

а) Байршил, хариуцлагын хэлбэр, ажиллагсдын тоо болон борлуулалтын орлогын бүлгээр



б) Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, мянган төгрөг



в) Худалдааны байршлаар, мянган төгрөг




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Худалдаа эрхлэгчдийн дийлэнх нь кассанд шаардлагатай бэлэн мөнгөө ATM, КИОСК-оос бүрдүүлдэг бөгөөд энэ эх үүсвэр бүх ангилалд давамгайл байр суурь эзэлж байна. Банкнаас шууд бэлэн мөнгө авах нь харьцангуй хязгаарлагдмал бөгөөд ихэвчлэн борлуулалтын орлого өндөр, эсвэл ажиллагсдын тоо олонтой бизнесүүдэд илүү ажиглагдаж байна. Салбарын хувьд хүнс, жижиглэн худалдаа, зах, мини маркет зэрэг өдөр тутмын борлуулалт давамгайлсан бизнесүүд ATM-д илүү түшиглэсэн бол үйлчилгээ, санхүү, мэдээллийн салбарт банк болон бусад эх үүсвэрийн оролцоо нэмэгдэж байна. Мөн худалдааны байршлаар авч үзвэл удаан эдэлгээт бараа, барилгын материал зэрэгт өөр эх үүсвэр (бусад харилцагчаас шууд)-ийн хэрэглээ харьцангуй өндөр байгаа нь бэлэн мөнгөний эргэлтийн зохион байгуулалт бизнесийн онцлогоос хамаарч ялгаатай байгааг илтгэнэ (Зураг 32).

Зураг 32. Бэлэн мөнгөний эх үүсвэр

а) Байршил, хариуцлагын хэлбэр, ажиллагсдын тоо болон борлуулалтын орлогын бүлгээр



б) Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар




в) Худалдааны байршлаар



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Бэлэн мөнгө авах гол зорилго нь кассын эргэлтийг хангах, хариулт мөнгө бэлдэх явдал бөгөөд энэ зорилго бусдаас тодорхой давамгайлж байна. Үүний дараа өдөр тутмын бэлэн төлбөр хүлээн авахад бэлтгэх, мөн богино хугацааны бэлэн мөнгөний дутагдлыг нөхөх зорилгоор бэлэн мөнгө авдаг байна. Харин урт хугацаанд хадгалах, эсвэл санхүүгийн хөрөнгө хэлбэрээр барих зорилго харьцангуй бага хувь эзэлж байгаа нь бэлэн мөнгө худалдаа эрхлэгчдийн хувьд хадгаламж бус, эргэлтийн хэрэгсэл хэвээр байгааг илтгэнэ. Энэ нь худалдаа эрхлэгчдийн бэлэн мөнгөний эрэлт нь гүйлгээний хэрэгцээнд суурилсан, богино хугацааны шинжтэй болохыг харуулж байна (Зураг 33).

Зураг 33. Бэлэн мөнгө авах зорилго




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь бэлэн мөнгөө АТМ, КИОСК төхөөрөмж ашиглан банканд байршуулж байгаа нь бүх ангилалд давамгайлж ажиглагдаж байна. Ялангуяа жижиг, өдөр тутмын борлуулалттай бизнесүүд болон хүнс, жижиглэн худалдаа, зах, мини маркет зэрэг байршлуудад АТМ-д суурилсан байршуулалт голлох хэвээр байна. Харин борлуулалтын орлого өндөр, ажиллагсдын тоо олонтой, мөн санхүү, мэдээлэл, үйлчилгээний салбарын хувьд банкаар дамжуулан байршуулалт хийх хувь харьцангуй өндөр байна. Энэ нь бэлэн мөнгө байршуулалтын арга нь зөвхөн дэд бүтцээс гадна бизнесийн хэмжээ, эргэлтийн дүн, цаг хугацааны зардалтай шууд уялдаатайг илтгэнэ (Зураг 34). Иймд АТМ-д төвлөрсөн байршуулалтын бүтэц нь бэлэн мөнгөний эргэлтийн бодлогод АТМ-ийн хүчин чадал, найдвартай байдал чухал болохыг харуулж байна.

Зураг 34. Бэлэн мөнгө байршуулах хэлбэр

а) Байршил, хариуцлагын хэлбэр, ажиллагсдын тоо болон борлуулалтын орлогын бүлгээр



б) Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



в) Худалдааны байршлаар




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь бэлэн мөнгөө ажлын өдөр бүр эсвэл долоо хоногт 1–3 удаа банканд байршуулдаг бөгөөд энэхүү давтамж жижиглэн худалдаа, хүнс, зах, мини маркет зэрэг өндөр эргэлттэй салбаруудад илүү давамгайл байна. Борлуулалтын орлого болон ажиллагсдын тоо нэмэгдэхийн хэрээр өдөр тутмын байршуулалтын хувь өсөх хандлагатай байгаа нь кассанд их хэмжээний бэлэн мөнгө удаан байлгах эрсдэлийг бууруулах зорилготой холбоотой. Харин үйлчилгээний зарим салбар, мөн борлуулалтын орлого багатай бизнесүүдийн хувьд сард 1–2 удаа эсвэл түүнээс ч бага давтамжтай байршуулалт ажиглагдаж байна. Худалдааны байршлаар авч үзвэл удаан эдэлгээт бараа, барилгын материалын худалдаанд байршуулалтын давтамж харьцангуй бага, харин өдөр тутмын хэрэглээ давамгайлсан байршлуудад өндөр давтамжтай байна. Энэ нь бэлэн мөнгө байршуулалтын давтамж нь дэд бүтэц бус, голчлон бизнесийн эргэлтийн хэмжээ, эрсдэлийн удирдлагатай уялдаатайг харуулж байна (Зураг 35).


Шигтгээ 4. Санхүүгийн хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Санхүүгийн хүртээмжийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг болох данс эзэмшлийн хувиар манай улс нь олон улсын түвшинд өндөрт тооцогдож байна. Тухайлбал, манай улсын насанд хүрсэн иргэд (15-с дээш насны)-ийн 98 % нь санхүүгийн данс эсвэл мобайл төлбөрийн хэрэгсэлтэй байгаа нь дэлхийн дундаж 79%-тай харьцуулахад өндөр бөгөөд дэлхийн бусад орнуудын дунд онцгой сайн үзүүлэлтэд тооцогддог байна (Зураг 36). Түүнчлэн 2024 оны байдлаар Монгол улсын 15-с дээш насны хүн амын 88% нь идэвхтэй карт эзэмшиж байгаа нь бусад улсуудтай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байгаа бөгөөд санхүүгийн бусад үйлчилгээг өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх голлох хүчин зүйл болж байна (Зураг 37).

Зураг 36. Санхүүгийн байгууллагад данс эзэмшлийн хувь, 2024



Зураг 37. Төлбөрийн карт эзэмшлийн хувь, 2024



Эх сурвалж: Дэлхийн банк

Мөн манай улсын 100,000 насанд хүрэгчид ноогдох АТМ-ын тоо 2023 оны байдлаар 31 байгаа бөгөөд өмнөд Азийн орнуудтай харьцуулахад өндөр, дэлхийн дунджаас бага зэрэг бага байна. Харин 2025 оны III улирлын байдлаар АТМ, СДМ, СРМ, КИОСК зэрэг бэлэн мөнгө байршуулах, авах үйлчилгээ бүхий төхөөрөмжийн нийт тоо 100,000 насанд хүрэгчид тутам 181 байгаа нь санхүүгийн хүртээмжийн хувьд манай улс хангалттай түвшинд хүрсэн гэж хэлж болохоор байна.

Зураг 38. АТМ-ын хүртээмж (100,000 насанд хүрэгчид ноогдох)



Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 39. АТМ-ын хүртээмж (100,000 насанд хүрэгчид ноогдох)




Эх сурвалж: Монголбанк, ҮСХ


Аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь борлуулалтын орлогынхоо 25 хүртэлх хувийг бэлэн мөнгөөр хүлээн авдаг бөгөөд энэхүү ангилал бүх бүлэгт давамгайл байна. Гэсэн хэдий ч жижиг хэмжээтэй, цөөн ажиллагсадтай ААН, ялангуяа хүнс, зах, жижиглэн худалдаа давамгайлсан салбаруудад бэлэн мөнгөний эзлэх хувь харьцангуй өндөр (25–50 хувь) байна. Харин борлуулалтын орлого өндөр, илүү үйл ажиллагаа нь хэвшсэн бизнесүүдэд бэлэн мөнгө огт авахгүй эсвэл маш бага (<25%) байх хандлага түгээмэл байна. Мөн борлуулалтын орлогын 50-с дээш хувийг бэлнээр авдаг ААН-үүдийн эзлэх хувь нийтдээ бага байгаа нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийн нэвтрэлт бизнесийн орчинд түгээмэл болохыг илтгэж байна (Зураг 40).

Зураг 40. Борлуулалтын орлогод бэлэн мөнгөний эзлэх хувь, интервалаар


а) Байршил, хариуцлагын хэлбэр, ажиллагсдын тоо болон борлуулалтын орлогын бүлгээр



б) Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



в) Худалдааны байршлаар



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

Бараа, үйлчилгээнийхээ үнийг “9”-өөр төгссөн байдлаар тогтоох нь бизнесийн практикт өргөн ашигладаг үнийн сэтгэлзүйн арга юм. Нөгөөтээгүүр хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийг бэлэн мөнгөөр төлөх үед хариулт өгөх шаардлагаар тухайн дэвсгэртийн эрэлтийг зохиомлоор өдөөдөг байж болзошгүй. Энэ үүднээс аж ахуйн нэгжүүд, худалдаа эрхлэгчид “9”-өөр төгссөн бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулдаг эсэх талаар тодрууллаа.

Аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ “9”-өөр төгссөн үнээр борлуулдаггүй бөгөөд бүх ангилалд “Үгүй” гэсэн хариулт 85–95 хувийг эзэлж байна. Байршил, борлуулалтын орлогын хэмжээ, ажиллагсдын тооноос үл хамааран “9”-өөр төгсгөлийн үнийг ашиглах түвшин маш бага (ихэвчлэн 5–15%) байна. Салбараар нь авч үзвэл хүнс, жижиглэн худалдаа зэрэг үнэ мэдрэг сегментүүдэд ч энэ арга тогтмол хэрэглээ болоогүй байна. Гэсэн хэдий ч зарим сүлжээ дэлгүүрүүд болон эмийн сангуудад “9”-өөр төгссөн үнэтэй бүтээгдэхүүн багагүй байна (Зураг 41).

Зураг 41. “9”-өөр төгссөн үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулдаг эсэх

а) Байршил, хариуцлагын хэлбэр, ажиллагсдын тоо болон борлуулалтын орлогын бүлгээр



б) Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



в) Худалдааны байршлаар




Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

4. МӨНГӨН ДЭВСГЭРТҮҮДИЙН ХЭРЭГЛЭЭ


Мөнгөн дэвсгэртүүдийн хэрэглээний ялгаатай байдлыг тодруулах зорилгоор иргэд, ААН-үүдээс мөнгөн дэвсгэртүүдийн ашигладаг давтамжийг тодруулсан бөгөөд иргэд, ААН-ийн мөнгөн дэвсгэртийн ашиглалт ойролцоо байна. Тодруулбал, дэвсгэртүүдийн дүн багасах тусам хэрэглээ эрс буурч, огт ашигладаггүй иргэд, ААН-ийн эзлэх хувь нэмэгдэж байна. Мөн “20000” төгрөг, “10000” төгрөг, “5000” төгрөгийн дэвсгэртүүд нь хамгийн өргөн хэрэглэгддэг бол “1000”-“10” хүртэлх төгрөгийн дэвсгэртүүд цөөнгүй тохиолдолд ашиглагдаж байна. Харин “1” болон “5” төгрөгийн дэвсгэртүүдийг судалгаанд хамрагдсан иргэд, ААН-үүдийн 93–96% нь огт ашигладаггүй гэж хариулсан нь эдгээр дэвсгэртүүд нь бараг хэрэглэгддэггүй болохыг харуулж байна (Зураг 42).

Зураг 42. Мөнгөн дэвсгэртүүдийг ашигладаг давтамж

а) Иргэдийн хувьд



б) Аж ахуйн нэгжүүдийн хувьд



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)


Шигтгээ 5. Мөнгөн тэмдэгтийн насжилт

Мөнгөн тэмдэгтийн насжилт гэж урагдсан, бохирдсон, шатсан, нууцлалын тэмдэг тэмдэглэгээ арилсан зэрэг шалтгаанаар бүрэн бүтэн байдал нь алдагдаж гүйлгээнээс татагдсан, устгагдсан мөнгөн тэмдэгтийн гүйлгээнд идэвхтэй эргэсэн хугацааг хэлнэ. Тус хугацаа нь мөнгөн тэмдэгтийн материал, түүний онцлог чанар, байгаль орчин, цаг уурын байдал, иргэдийн цаасан мөнгөтэй харьцах хэвшил болон мөнгөн дэвсгэртийн төрлөөс шалтгаалан харилцан адилгүй байдаг.

Манай орны хувьд мөнгөн дэвсгэртийн дундаж наслалт 2024 оны байдлаар дунджаар 4.7 жил байна. Энэ нь 2015 оны үетэй харьцуулахад 1.2 жилээр уртассан үзүүлэлт юм. Мөнгөн дэвсгэрт бүрээр харвал хамгийн удаан насжилттай дэвсгэрт “10,000” төгрөг буюу 6.3 жил байдаг бол хамгийн бага насжилттай дэвсгэрт “1,000” төгрөг буюу 2.9 жилтэй байна (Зураг 43).

Мөн 1 болон 5-ын дэвсгэртүүдийн хувьд банкуудаар дамжуулан зузаатгалаар гардаг боловч эргэн устгалд ордоггүй эсвэл бага хэмжээгээр устгалд ордог буюу дийлэнх тохиолдолд иргэдийн гар дээр үлддэг байна. Иймээс тус дэвсгэртүүдийн хувьд дундаж насжилтыг бодитоор харуулж чадахгүй байгааг энд онцлох нь зүйтэй.

Зураг 43. Мөнгөн дэвсгэртүүдийн насжилт, жилээр



Эх сурвалж: Монголбанк, Мөнгөн тэмдэгтийн мэдээллийн сан

Бага нэрлэсэн дүнтэй дэвсгэртүүд (\$1–\$10, €5–€20 гэх мэт) бүх улсуудад хамгийн богино насжилттай байдаг. Энэ нь өдөр тутмын гүйлгээнд өндөр давтамжтай ашиглагддагтай шууд холбоотой. Харин их дүнтэй дэвсгэртүүд (\$50–\$100, €100–€200 гэх мэт) нь хадгалалт, том дүнгийн гүйлгээнд илүү ашиглагддаг тул харьцангуй урт насжилттай. Олон улсын туршлагаас харахад мөнгөн дэвсгэртийн насжилт нь зөвхөн нэрлэсэн дүнгээс гадна төлбөр тооцооны зан төлөв, материал, бэлэн бус төлбөр тооцооны хөгжлөөс ихээхэн хамаардаг. Гэсэн хэдий ч

голлох дэвсгэртүүдийн төрлүүдтэй харьцуулахад төгрөгийн дундаж насжилт ойролцоо байна (Зураг 44).

Зураг 44. Мөнгөн дэвсгэртүүдийн насжилт олон улсад



Энэхүү түүвэр судалгаагаар хэрэглээнд байгаа мөнгөн дэвсгэртийг сайжруулах иргэд, ААН-ийн саналыг мөн тодрууллаа. Одоо хэрэглээнд байгаа мөнгөн дэвсгэртүүдийг өөрчлөх шаардлагагүй гэж судалгаанд хамрагдсан иргэдийн багагүй хувь нь буюу 40%, ААН-ийн 47% нь үзэж байна. Харин цаасны чанарыг сайжруулах шаардлагатай гэж иргэдийн 21%, ААН-ийн 18% нь, нууцлалын элементийг сайжруулах гэж иргэдийн 14%, ААН-ийн 12%, загвар дизайныг сайжруулах шаардлагатай гэж иргэдийн 9%, ААН-ийн 6% нь тус тус хариулжээ. Өөрөөр хэлбэл, иргэд, ААН-үүд өнөөгийн хэрэглэгдэж байгаа мөнгөн дэвсгэртүүдийн шинж чанартай холбоотой үзүүлэлтээр харьцангуй боломжийн гэж үнэлжээ (Зураг 45).

Зураг 45. Мөнгөн дэвсгэртүүдийг өөрчилж, сайжруулах санал



Эх сурвалж: Монголбанк, “Бэлэн мөнгөний хэрэглээний түүвэр судалгаа” (2025)

5. ДҮГНЭЛТ

Бэлэн мөнгөний хэрэглээ нь өдөр тутмын төлбөр тооцоонд мөнгөн тэмдэгт (*цаасан дэвсгэрт, зоос*)–ийг ашиглан гүйцэтгэсэн гүйлгээний давтамж, үнийн дүн, бүтэц болон зан төлөвийг илэрхийлэх цогц ойлголт юм. Энэхүү судалгаанд бэлэн мөнгөний хэрэглээг (i) урсгал (flow) үзүүлэлтээр буюу тухайн өдөр бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр тооцооны нийт дүн, тоо, нөөц (*stock*) үзүүлэлт буюу өдрийн эхэн болон эцэст биедээ авч явж буй бэлэн мөнгөний хэмжээ зэргээр тодорхойлж, иргэдийн бэлэн мөнгө ашиглах болон хадгалах зан төлөвийг цогцоор нь үнэллээ.

Ингэхдээ иргэд, бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн дунд 2025 оны 10-11 дүгээр саруудад түүвэр судалгаа зохион байгуулсан бөгөөд тус судалгаанд байршил, насны ангилал, хүйс, орлогын бүлгээр эх олонлогийн бүтцийг хангасан 2,131 иргэд болон 540 бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд нь голлон жижиг, дунд хэмжээний худалдаа эрхлэгчид тул гарсан үр дүнг бүх салбар, бүх хэмжээний ААН-д шууд ерөнхийлөх боломж хязгаарлагдмал гэдгийг онцлох нь зүйтэй. Гэсэн хэдий ч иргэдийн өдөр тутмын төлбөр тооцоо хамгийн их хийгддэг худалдаа, үйлчилгээний цэгүүд хамрагдсан нь худалдаа эрхлэгч талаас бэлэн мөнгөний хэрэглээний бодит дүр зургийг тодорхой хэмжээнд тусгаж чадсан гэж үзэж байна. Судалгааны голлох үр дүнгүүдээс тоймловол:

- Иргэдийн бэлэн мөнгөөр хийж буй төлбөр тооцоо нь ихэвчлэн бага дүнтэй, өдөр тутмын хэрэглээнд илүү төвлөрч байгаа нь бэлэн мөнгөний өдөр тутмын хэрэглээнд гүйцэтгэж буй үүрэг хэвээр байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 72% нь бэлэн мөнгө биедээ авч явдаг, харин 28% нь огт бэлэн мөнгө авч явдаггүй байна. Иргэд дунджаар (медиан утгаар) өдрийн эхэнд 10,000 төгрөгийн бэлэн мөнгөтэй гарч, 20,000 мянган төгрөгийн бэлэн мөнгө АТМ, КИОСК зэрэг төхөөрөмжөөс татан авч, өдөр тутамдаа 16,000 мянган төгрөгийг бэлнээр зарцуулан, өдрийн эцэст ойролцоогоор 14,000 төгрөгийн бэлэн мөнгө үлддэг байна.
- Иргэд өдөр тутмын нийт төлбөр тооцооны тоо хэмжээний дунджаар 27%, үнийн дүнгийн 18%-ийг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байна. Ялангуяа тэтгэврийн ахмад настан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд бэлэн мөнгөний хэрэглээ бусад бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Үүний зэрэгцээ судалгаанд оролцсон иргэдийн 15% нь бэлэн мөнгө огт ашигладаггүй, 43% нь сард цөөн удаа ашигладаг нь нийт хүн амын дунд бэлэн мөнгөний хэрэглээ өргөн хүрээнд бус, тодорхой хэрэглээний нөхцөлд төвлөрч байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, бэлэн мөнгө нь жижиг дүнтэй, ойр

зуурын гүйлгээнд ашиглагддаг бол бэлэн бус төлбөрүүд нь дунд, их дүнтэй гүйлгээнд зонхилон ашиглагдах төлөвшил бий болжээ.

- Нөгөө талаас бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн дийлэнх буюу 84% нь бэлэн төлбөр тооцоог хүлээн зөвшөөрдөг, бэлэн бус төлбөрийн хэрэгслийг худалдаа үйлчилгээндээ өргөнөөр нэвтрүүлсэн байна. Ялангуяа худалдаа эрхлэгчид бэлэн мөнгөөр төлбөр хүлээн авах давтамж харьцангуй өндөр байгаа нь тэдний сонголтоос илүүтэйгээр хэрэглэгчдийн төлбөр тооцооны зан төлөвийг илүү тусгаж байна.
- Бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн 32% нь кассандаа бэлэн мөнгө байршуулдаггүй эсвэл хариулахаас татгалзсан бол кассандаа бэлэн мөнгө байршуулдаг бизнес эрхлэгчдийн кассын дундаж үлдэгдэл ойролцоогоор 500,000 төгрөг байна. Тэд шаардлагатай үедээ бэлэн мөнгө татан авах эсвэл байршуулахдаа ихэвчлэн АТМ, КИОСК зэрэг өөртөө үйлчлэх төхөөрөмжийг ашигладаг бөгөөд борлуулалтын орлогынхоо 25 хүртэл хувийг бэлэн мөнгөөр хүлээн авдаг байна.
- Иргэд болон худалдаа эрхлэгчдийн дунд “20,000”, “10,000”, “5,000” төгрөгийн дэвсгэртүүд хамгийн өргөн хэрэглэгддэг бол “1” болон “5” төгрөгийн дэвсгэртүүдийг судалгаанд хамрагдсан иргэд, ААН-үүдийн 93–96% нь огт ашигладаггүй байна.